



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/543

Арвайхээр

「 Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай 」

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.д, 29.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг салбар дундын нэгдсэн удирдлагаар хангах, үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх ажлыг удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж, үр дүнг жил бүр Засаг даргын зөвлөлийн хурлаар тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/15 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101245

Аймгийн Засаг даргын 2020 оны 12
дугаар сарын 13-ны өдрийн 1378 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Гишүүд: Арвайхээр сумын Засаг дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
Аймгийн Насан туршийн боловсрол төвийн захирал
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хүнс хөдөө аж ахуй, үйлдвэрлэл худалдаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрийн Нийгмийн бодлогын хэлтсийн Хүүхэд, гэр бүл, залуучууд, соёл урлаг, спортын салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн
Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн
Аймгийн Засаг дарга дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Хүүхдийн эрх, хөгжил хамгаалал, нийгмийн ажил, дотуур байр, хэвлэл мэлээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
Дэлхийн зөн олон улсын байгууллагын “Өрхийн хөгжил–320” тусгай төслийн менежер
Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Өвөрхангай аймаг дахь салбарын төлөөлөл (Зөвшилцсөнөөр)
Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүй, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
Дэлхийн зөн олон улсын байгууллагын Өвөрхангай аймаг дахь Дотоодын хүүхдийг ивээн тэтгэх хөтөлбөрийн зохицуулагч

Аймгийн Засаг даргын 2020 оны 12...
дүгээр сарын 15-ны өдрийн 1514 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Өвөрхангай аймагт Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд харилцан дэмжлэг үзүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах зорилготой.

1.2.Хөтөлбөрийн арга аргачлалыг орон нутагт нутагшуулах, мэдээ, мэдээллийг харилцан солилцох, зорилтот бүлгийн айл өрхүүд, хүүхдүүдийн сайн сайхан амьдралыг цогцлоон бүрдүүлэхийн төлөө харилцан дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллана.

1.3Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд харилцан мэдээлэл, туршлага солилцон, нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэн орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллана.

Хоёр. Ажлын хэсгийн хуралдаан

2.1.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн жилд 3-аас доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийн дарга болон гишүүдийн олонхийн саналаар хуралдаж болно.

2.2.Гишүүдийн олонхи хуралд ирснээр хурал хүчинтэйд тооцогдоно.

2.3.Гишүүд салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал боловсруулан, хурлаар хэлэлцүүлж болно. Гишүүд ажлын хэсгийн хурлаар болон төлөвлөгөөний дагуу даалгасан үүргийг хугацаанд нь биелүүлж явц, үр дүнг хурлаар танилцуулна.

2.4.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

2.4.Гишүүд ажлын хэсгийн хуралд заавал оролцох, хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд хариуцсан ажилтанг даргын зөвшөөрөлтэй оролцуулна.

2.5.Хурлын нарийн бичгийн дарга хурлын явцын тухай тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1.Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санал, зөвлөмж гаргах, төлөвлөгөө хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор санал дэвшүүлэх эрхтэй.

3.2.Салбар дундын хамтын ажиллагаатай хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөнд тусгахдаа нарийн зохицуулалт хийнэ.

3.3.Төрийн байгууллагаас шаардлагатай тайлан, судалгаа, статистик мэдээллийн холбогдох байгууллагад өгөх үүрэгтэй

3.4.Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагаас хөтөлбөрийн арга аргачлал, үйл ажиллагааны тайланг төрийн холбогдох байгууллагад хүргүүлэх үүрэгтэй

3.5.Ажлын хэсгийн гишүүд төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг жил бүрийн 5 болон 11 сард Нарийн бичгийн дарга нарт өгч байх үүрэгтэй.

-oOo-